



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 16 өдөр

Дугаар А/254

Бат-Өлзий сум

Шууд гэрээ байгуулах тухай

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэг, 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсэг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны төсвийн тодотгол батлах тухай” 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 22/01 дүгээр тогтоолын 7 дугаар хавсралтын тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ажлын хэсгийн 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 01 дүгээр хурлын шийдвэрийг үндэслэн Сум дундын Ойн ангийн мод үржүүлгийн газарт усалгааны систем худалдан авах ажлыг иргэн Ц.Цэрэнжигмэдтэй шууд худалдан авах гэрээгээр гүйцэтгүүлсүгэй.

2.Ц.Цэрэнжигмэдтэй гэрээ байгуулж, Сум дундын Ойн ангийн мод үржүүлгийн газарт усалгааны систем худалдан авах ажилд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

3.Ц.Цэрэнжигмэдэд ажилд шаардагдах 12,600,000 (арван хоёр сая зургаан зуун мянга) төгрөгийг гэрээнд заасны дагуу Байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдулам)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  Н.ОРХОНТУУЛ

